



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ ХӨГЖЛИЙН
ХӨТӨЛБӨР НАМД

2024.08.05 № ТНАГ-2024/ВЗ-ШТА-Н-29
танай _____ -ны № _____ -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хөгжлийн хөтөлбөр намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-

2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөгжлийн хөтөлбөр намын аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


Хөгжлийн хөтөлбөр намын мөрийн хөтөлбөр /..... хуудас /-ийг хавсаргав.

Хувийг: Хөгжлийн хөтөлбөр намд

Хувийг: Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА






**ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР
НАМ**

**“ХӨГЖИНГҮЙ МОНГОЛ
ХӨГЖЛИЙН ШИНЭ ГАРЦ”
ХӨТӨЛБӨР
/2024-2028/**

(Хөгжлийн хөтөлбөр намын
Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчийн хурлын
2024 оны сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр)

**Улаанбаатар хот
2024 он**

ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ АГУУЛГА



- ❖ Иргэнээ дээдэлсэн “Хүн төвтэй”, ардчилсан иргэний нийгмийг төлөвшүүлж, хариуцлага, ёс суртахуунтай шударга төрийн залгамж чанарыг үргэлжлүүлэх.
- ❖ Эдийн засгийн тогтвортой нөхцөлийг хангаж, дотоодын нөөц баялагт түшиглэсэн үйлдвэржсэн аймаг болоход орон нутгийн баялаг нөөц бололцоо ард иргэдийн санал санаачилгад тулгуурлах.
- ❖ Орон нутагт санхүүгийн сахилга батыг сайжруулж, ил тод байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх.
- ❖ Эрүүл, ажил, орлоготой дундаж давхаргыг бий болгох бодлого баримтална.
- ❖ Эрчим хүчний үнэ тарифыг бууруулах оновчтой саналыг дэмжиж, үнийн хөөрөгдөлтийг зогсоох бодлого баримтална.
- ❖ Ногоон хөгжлийг дэмжин, эрүүл ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх.
- ❖ Бизнесийн орчныг эрүүлжүүлж зөв хөгжилд оруулах ажлыг эрчимжүүлэх.
- ❖ Айх аюулгүй, амар түвшин, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.



НИЙГЭМ



ЭДИЙН ЗАСАГ



БАЙГАЛЬ ОРЧИН

**Хөгжлийн хөтөлбөр намын Сэлэнгэ аймгийн
иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2024 оны сонгуульд оролцох
мөрийн хөтөлбөр**

Алсын хараа

Ард иргэдийн эв нэгдлийг бататган “Хүнээ дээдэлсэн” хүн төvtэй шударга, ардчилсан, аз жаргалтай, эрүүл нийгмийг төлөвшүүлж хөгжүүлэх нь орон нутгийн хөгжлийн бодлогын цөм байх болно.

1. Улс төрийн зорилт, хөтөлбөр

Зорилтын агуулга:

Монгол улсын эрхэм дээд баялаг бол Монгол хүн мөн. Монгол хүн төрийн хамгаалалтад байж хөгжлийн бодлогыг зорилго бүр нь Монгол хүний сайн сайхан байдлыг дээшлүүлж эрүүл байлган урт наслуулахад чиглэх болно.

Ардын уламжлалт ахуй соёл, сэтгэхүй, оюун санааны өвийг дээдлэн хөгжүүлж иргэн бүр ажил, сургууль, орлоготой байж ядуу иргэнгүй, нийгмийн чинээлэг дундаж давхаргатай, эдийн засгийн эрх чөлөө, хувийн хэвшил, өмчийн халдашгүй дархан байх эрхийг хуулиар чанд сахин хамгаалсан иргэний ардчилсан шударга нийгмийг байгуулах нь ард түмнийхээ эрх ашгийг дээдэлсэн Монгол орны оршин тогтоно, хөгжин цэцэглэх, сэрэн мандахыг үндэс болсон аймаг, орон нутгаас эхэлнэ.

1.1 Ард иргэдээ намын харьялал, нутаг ус, итгэл үнэмшил, сүсэг бишрэл, өмч хөрөнгөөр нь алагчлан зааглаж, хуваан өмчлөх үзэгдлийг эцэс болгож, нийгмийн талцал, хуваагдлын үндэс болсон улс төрийн намын хатуу гишүүнчлэлгүй байх бодлогыг уламжлан хууль эрх зүйн орчныг бий болгох санаачилгыг дэвшүүлэх.

1.2 Улс төрийн намаас сонгогдсон төлөөллөөрөө дамжуулан хариуцлага сахилга батыг бүх шатанд чангатгаж, төрийн албан хаагчид хээл хахууль авилгийн хэрэг үйлдсэн тохиолдолд хүлээх ял шийтгэлийг хүндрүүлж, төрийн албанад ажиллах эрхийг нь хязгаарлах санаачилгыг өрнүүлэх.

1.3 Ард иргэдийг талцалд хүргэсэн нийгмийн амьдралын гол зангилаа асуудлууд түүний дотор Үндсэн хуулиар бүх ард түмний мэдэлд байхаар заасан асуудлыг ард түмний санал асуулгаар шийддэг байх санал санаачилга гаргаж, хэрэгжүүлэх.

1.4 Жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор улс төрийн намууд бүх шатны сонгуульд нэр дэвших эмэгтэйчүүдийн квотыг 40%-иар тогтоох, төрийн албаны удирдах ажилтны 35-40%-ийг эмэгтэй нэр дэвшигчдээс сонгох бодлогыг дэвшүүлнэ.

1.5 Нүүдлийн соёл иргэншлийн үндэс болсон малчин, мал, бэлчээрийн газар нутгийн дархлааг хангасан хууль эрх зүйн тогтвортой орчныг бий болгох санаачилгыг дэвшүүлэх.

2. Эдийн засгийн хөгжлийн зорилт, хөтөлбөр

Орон нутгийн эдийн засгийн тусгаар тогтнолыг тууштай сахин бэхжүүлж, эрчим хүч, түүхий эдийн нөөцөө түшиглэн инновацын хүч, орчин үеийн тэргүүний техник технологийг ашиглаж өндөр үр ашигтай, тогтвортой, өөрийн хуримтлалаар өсөж хөгжих, өөрийгөө нөхөн тэтгэх, гадаад орчны өөрчлөлтөд дасан зохицох чадвартай эдийн засгийн нэгдсэн орон зайг бий болгохыг зорино.

2.1 Орон нутгийн эдийн засгийн бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөж, шинжлэн судалж, хэрэгжүүлдэг байх. Эдийн засгийн бодлого, хэтийн төлөвийг тодорхойлох, төсөөлөхдөө дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

- Хүний хөгжил
- Эв зохицлой хөгжил
- Тэнцвэртэй хөгжил
- Ногоон хөгжил
- Хуримтлалтай хөгжил
- Хөрш орнуудтай хорших хөгжил

2.2 Эдийн засгийн эрх зүйн орчныг бүхэл цогцоор дараах шаардлагуудад нийцүүлэн төгөлдөржүүлэн хэрэгжүүлэх, бүтцийг шинэчлэх:

- 2.2.1 Орон нутагт эдийн засгийн уналтыг зогсоох, тогтвожуулах, өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлэх.
- 2.2.2 Орон нутгийн эдийн засгийн өсөлт, аюулгүй байдал, тогтвортой байдлыг хангах.
- 2.2.3 Төр, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааны тогтвортой орчныг бүрдүүлэх бодлого баримтална.
- 2.2.4 Гадаадын хөрөнгө оруулагчдад тавих шаардлага, хамтарч ажиллах гэрээ хэлэлцээрүүдэд үндсэн хууль болон бусад хуулийг чанд мөрдөж орон нутгийнхаа эрх ашгийг тууштай хамгаалах чадавхыг бий болгох.

2.3 Орон нутгийн эдийн засгийн бүтцийг нягтуулж, түлш, шатахуун, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, аж үйлдвэрийн салбарт өндөр технологи бүхий бага, дунд оврын үйлдвэрүүдээр түүхий эдийг боловсруулахыг дэмжсэн бодлого баримтална.

2.3.1 Сэргээгдэх эрчим хүчийг түлхүү хөгжүүлж орон нутгаа эрчим хүчний хараат бус болгох бодлого баримтална.

2.3.2 Олборлолт-Экспортын чиг хандлагатай уул уурхайн салбарыг Олборлолт - Боловсруулалт - Экспортын чиг хандлагатай болгон өөрчлөхөд орон нутгийн бодлогыг чиглүүлэх.

2.3.3 Эрдэс түүхий эдийн баялгийг ариг гамтай, байгаль экологид хор хөнөөл учруулахгүйгээр олборлож, хамгийн үр ашигтай, хөрөнгө оруулалтаа богино хугацаанд нөхөж, үр өгөөжөө өгөх технологийн шатанд хүртэл боловсруулж, орон нутгийн дотоод хэрэгцээгээ бүрэн хангаж, экспортын тогтвортой нөөц, эх үүсвэр бүрдүүлэхийг дэмжих.

2.4 Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлээр ард иргэдийнхээ хүнсний хэрэгцээг гений өөрчлөлтгүй, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, экспортлох хэмжээнд хүртэл тэтгэн хөгжүүлж, малчид, тариаланчдыг үнийн хэт алдагдалтай өөрчлөлт, зээлийн өрийн дарамтаас хамгаалах бодлого хэрэгжүүлэх.

2.4.1 Мал аж ахуй, газар тариалан, хүнсний ногооны бүтээгдэхүүнийг хамгийн өндөр технологиор иж бүрэн боловсруулах, дэлхийн стандартад нийцсэн экспортод гаргах чадамжийг бий болгож харилцан уялдаатай жижиг дунд үйлдвэрийг байгуулсан аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжих.

2.4.2 Ард иргэдийнхээ хүнс тэжээлийн хэрэгцээг гений өөрчлөлтгүй экологийн цэвэр бүтээгдэхүүнээр найдвартай хангаж, уламжлалт болон эрчимжсэн технологийг оновчтой хослуулан газар тариалан, жимс ногоо боловсруулах кластераар хөгжүүлэх санал санаачилгыг дэмжих.

2.4.3 “Хашаандаа сайхан амьдарна” уриа дор аймаг, сум, суурин газрын гэр хороололд өрхийн бичил үйлдвэрлэл хөгжүүлэх бодлого баримтална.

3.Нийгмийн хөгжлийн зорилт хөтөлбөр

3.1 “Хүн” төвтэй нийгмийн хөгжлийн бодлого баримталж, иргэдийнхээ амьдралын аюулгүй байдал, амьдралын баталгааг сайжруулах, ядуурлыг бууруулж нийгмийн дундаж давхаргыг тэлэх бодлого баримтална.

3.2 Боловсролын салбарын сургалтын хөтөлбөрийг орчин цагийн шинжлэх ухааны боловсрол олгох шаардлагад нийцүүлэх, Монгол бичиг, кирилл бичиг эзэмших “Хос бичигтэн”, гадаад хэл эзэмших “Хос хэлтэн” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх бодлого баримтална.

3.2.1 Хүүхэд, залуучуудын эх хэлний мэдлэгийг сайжруулах бодлогыг дэмжих.

3.2.2 Мэргэжилтэй ажилчин бэлтгэх шаардлагын дагуу орчин үеийн техник, тоног төхөөрөмж материаллаг баазаар хангагдсан сургуулиудад залуучуудыг сургаж, буцаан орон нутагтаа ажиллах боломжийг бүрдүүлэх бодлого баримтална.

3.3 Эмнэлгийн үйлчилгээг цогцоор хөгжүүлж юуны өмнө, түгээмэл тархаж, иргэдийн эрүүл мэнд амь насанд ноцтой аюул учруулж буй өвчинөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх боловсон хүчний материаллаг баазуудыг бэхжүүлэх бодлого баримтална.

3.4 Монгол соёл иргэншлийн дэвшилтэт ололт, үнэт зүйлсийг уламжлал шинэчлэлийн ухаалаг зөв харьцаанд хадгалан, хамгаалах хөгжүүлэх замаар дэлхийн соёл урлагт үндэснийхээ соёлын эзлэх байр суурийг бэхжүүлэн, Монгол хэл, соёл мөхөж дорийтох, өөр үндэсний хэл, соёлд уусан замхрах, өв уламжлал, ёс заншил алдагдах, оюун санааны амьдрал ядууран дорийтохоос сээрэмжлэхэд соёл урлагийн бодлогын зорилтыг чиглүүлнэ.

3.4.1 Үндэсний язгуур урлаг, уртын дуу, сонгодог урлагийн үндсэн төрлүүд болох. Сонгодог хөгжим, бүжгэн жүжиг, дуурь, уран зураг, баримлын урлагийг төр ивээлдээ авахыг уламжлан дэмжүүлэх бодлого баримтална.

3.4.2 Урлагийн гоц авьяастай хүүхэд, залуучууд, ард иргэдийг алдаршуулан дэмжин хөгжүүлэх бодлого баримтална.

3.5 Их спорт, нийтийн биеийн тамирыг харилцан уялдаатай хөгжүүлж, тамирчдаа бэлтгэх

4. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлэх бодлого.

Үндсэн бодлого чиглэл:

- ✓ Байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан, эко системийн тогтвортой байдлыг хадгалах замаар хүртээмжтэй өсөлтийг бий болгох.
- ✓ Баталгаат үндны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэн ариун цэврийн байгууламжийг орон нутгийн бодлогын салшгүй хэсэг болгох.
- ✓ Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эх, булаг шандыг хамгаалж нөөцийг нэмэгдүүлэх.
- ✓ Төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлого үзэл баримтлалд Монгол угсаатны нүүдлийн соёл иргэншлийг шингээсэн 4 улирлын өнгө төрх үзэсгэлэнт түүх соёлын дурсгалт газар, археологийн олдвор, дэлхийд нэн ховордсон биологийн олон төрөл зүйл зэрэг давуу талуудыг зүй зохистой хослуулсан, гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээ сонирхолд нийцсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх.

4.1 Байгаль орчноо хамгаалан тэтгэж, хүрээлэн буй орчныг эрүүлжүүлэх бодлогыг шинэ шатанд гаргахад орон нутгийн бодлогыг чиглүүлэх.

4.1.2 Үндны усыг аж ахуйн зориулалтаар хэрэглэхийг багасгахад хүчтэй түлхэц өгөх эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд орон нутгийн бодлогыг чиглүүлэх.

4.1.2 Ховордсон ан амьтныг өсгөх, ховордсон ургамлын сэргэн ургалтыг дэмжих бодлого баримтална.

4.2 Байгаль орчны нөхөн сэргээлт хийгээгүй аж ахуйн нэгжүүдийг хар жагсаалтад оруулах, уул уурхайн үйл ажиллагаа эхлэх гэрээ хэлцлийг хийхгүй байх бодлого баримтална.

4.3 Байгалийн унаган байдлыг хадгалах замаар тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого баримтална.

4.4 Гадаад дотоодын аялал жуулчлалыг нутгийн иргэдийн шууд оролцоонд тулгуурлаж, орчин үеийн шаардлагад нийцсэн аятай тухтай нөхцөлийг бүрдүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагуудын хариуцлагыг дээшлүүлж шинэ шатанд гаргах бодлого баримтална.

**ХҮН БҮР ЭРҮҮЛ ЭНХ, ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ, АЗ ЖАРГАЛТАЙ
АМЬДРАХ БОЛТУГАЙ.**

---0000oo---